ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Ерөнхий Боловсролын сургууль 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ӨВА-2022/13/НА-СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: Б.Алтанцэцэг

Утас: 99016193 Цахим хаяг:altaa_6116@yahoo.com


Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
3. Аудитын тайлан ........ 13
3.1 Ерөнхий зүйл ........ 13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 14
3.4 Материаллаг байдал ........ 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 15
3.8 Аудитын гол асуудал ........ 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16
4. Аудитын илрүүлэлт ........ 16
4.1 Залруулсан алдаа ........ 16
4.2 Төлбөрийн акт ........ 16
4.3 Албан шаардлага ........ 16
4.4 Зөвлөмж ........ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 16


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.14 № 143
танай ________-ны №__________-т

ЕСӨН ЗҮЙЛ СУМЫН ЕБСУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.БОЛОРМАА ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Есөнзүйл сумын ББСургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Есөнзүйл сумын ББСургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **98,676,258.00** | **102,827,406.00** |
| **33** | **АВЛАГА** | 8,600,000.00 | - |
| 33500 | Бусад авлага | 8,600,000.00 | |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 8,600,000.00 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **90,076,258.00** | **102,827,406.00** |
| **35100** | **Түүхий эд материал** | 351,431.00 | 199,844.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 351,431.00 | 199,844.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | 89,724,827.00 | 102,627,562.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 214,000.00 | 189,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 550,000.00 | 550,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | | 1,480,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 16,594,587.00 | 15,239,572.00 |
| 35600 | Мал амьтад | 6,310,000.00 | 5,900,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 66,056,240.00 | 79,268,990.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,663,360,133.17** | **4,304,349,491.39** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **4,663,360,133.17** | **4,304,349,491.39** |
| **39200** | **Биет хөрөнгө** | 4,631,222,132.85 | 4,272,345,490.99 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,543,448,898.43 | 4,367,117,340.83 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (131,437,843.44) | (330,700,417.92) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 125,486,117.26 | 157,072,117.26 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (39,549,618.66) | (79,004,332.73) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 110,074,362.80 | 143,207,362.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (27,149,399.54) | (38,300,957.57) |
| 39217 | Номын фонд | 50,349,616.00 | 52,954,378.32 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 32,138,000.32 | 32,004,000.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 39301 | Програм хангамж | 1,340,000.00 | 1,340,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (571,999.68) | (705,999.60) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 31,370,000.00 | 27,370,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,762,036,391.17** | **4,403,176,897.39** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **8,069,455.67** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | 8,069,455.67 |
| **413** | **Өглөг** | 0.00 | 8,069,455.67 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 8,069,455.67 |
| 413102 | НДШ-ийн өглөг | 0.00 | 5,895,493.00 |
| 413103 | ХАОАТ-ын өглөг | 0.00 | 2,173,962.67 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,762,036,391.17** | **4,395,107,441.72** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **4,762,036,391.17** | **4,395,107,441.72** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 557,604,902.64 | 553,604,902.64 |
| 51101 | Өмч: - төрийн | | |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,639,948,638.75 | 3,650,383,070.50 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 706,679,480.07 | 4,005,242,564.28 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 2,933,269,158.68 | (362,928,949.45) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 564,482,849.78 | 199,188,924.25 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,762,036,391.17** | **4,403,176,897.39** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,940,631,106.06** | **1,073,885,395.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,996,474,106.06** | **93,273,812.32** |
| **1200** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,996,474,106.06 | 93,273,812.32 |
| 120009 | Бусад нийтлэг татварын бус орлого | 20,278,262.06 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 2,971,535,566.00 | 74,171,362.32 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 4,660,278.00 | 19,102,450.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **944,157,000.00** | **980,611,583.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **Улсын төсвөөс** | **761,047,900.00** | **759,884,200.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс шилжүүлэх | 761,047,900.00 | 759,884,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | **11,657,800.00** | **5,392,983.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 11,657,800.00 | 5,392,983.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **171,451,300.00** | **215,334,400.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 171,451,300.00 | 215,334,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,007,361,947.38** | **1,231,836,001.29** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,007,361,947.38** | **1,231,836,001.29** |
| **210** | **БАРАА,АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 982,800,450.91 | 1,198,682,486.77 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 635,964,218.00 | 618,191,727.89 |
| 210101 | Үндсэн цалин | 421,376,500.00 | 408,366,844.45 |
| 210102 | Нэмэгдэл | 165,281,718.00 | 165,004,596.44 |
| 210104 | Урамшуулал | 49,306,000.00 | 44,820,287.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **81,061,681.53** | **79,743,356.26** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 55,509,302.69 | 55,655,616.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,440,044.80 | 6,182,305.36 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,335,156.32 | 4,952,313.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,103,359.84 | 1,178,143.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,673,817.88 | 11,774,977.49 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **142,682,904.00** | **175,911,216.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,885,199.00 | 4,662,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 137,897,705.00 | 171,249,216.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,900,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **14,674,100.00** | **11,757,348.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 436,700.00 | 587,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,800,000.00 | 2,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 39,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 228,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,400.00 | 293,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,847,000.00 | 2,299,098.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,290,000.00 | 6,310,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **31,245,588.00** | **39,498,340.00** |
| 210501 | Эм эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл | 243,500.00 | 239,100.00 |
| 210502 | Хоол хүнс | 30,237,288.00 | 38,609,240.00 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 764,800.00 | 650,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,917,800.00** | **5,945,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210604 | Урсгал засвар | 7,917,800.00 | 5,945,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **495,100.00** | **483,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 495,100.00 | 483,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,982,100.00** | **629,966.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,406,100.00 | 389,966.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **66,776,459.38** | **266,522,532.62** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 339,300.00 | 331,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,829,400.00 | 5,400,272.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 64,607,759.38 | 260,791,160.62 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **24,561,496.47** | **33,153,514.52** |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг | 2,573,100.47 | 19,405.52 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,573,100.47 | 19,405.52 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт | 20,968,396.00 | 8,603,184.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,968,396.00 | 8,603,184.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,020,000.00 | 24,530,925.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | | 22,340,925.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,020,000.00 | 2,190,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **204,978,343.48** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,933,269,158.68** | **(157,950,605.97)** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | **204,978,343.48** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | | 204,978,343.48 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 204,978,343.48 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5 =(3)+(4)** | **2,933,269,158.68** | **(362,928,949.45)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 557,604,902.64 | 564,482,849.78 | 3,639,948,638.75 | 4,762,036,391.17 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 557,604,902.64 | 564,482,849.78 | 3,639,948,6 8.75 | 4,762,036,391.17 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | 0.00 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 557,604,902.64 | 564,482,849.78 | 3,639,948,638.75 | 4,762,036,391.17 |
| D01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 557,604,902.64 | 564,482,849.78 | 3,639,948,638.75 | 4 762,036,391.17 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 365,293,925.53 | 365,293,925.53 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 557,604,902.64 | 564,482,849.78 | 4,005,242,564.28 | 5,127,330,316.70 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0 00 | (365,293,925.53) | 0.00 | (365,293,925.53 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (362,928,949.45) | (362,928,949.45) |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 557,604,902.64 | 199,188,924.25 | 3,642,313,614.83 | 4,399,107,441.72 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **944,157,000.00** | **980,611,583.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **944,157,000.00** | **980,611,583.00** |
| 1310 | Улсын төсвөөс | 761,047,900.00 | 759,884,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 761,047,900.00 | 759,884,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 11,657,800.00 | 5,392,983.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 11,657,800.00 | 5,392,983.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 171,451,300.00 | 215,334,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 171,451,300.00 | 215,334,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **933,617,000.00** | **956,624,083.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **933,617,000.00** | **956,624,083.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **899,188,403.53** | **920,243,993.48** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **635,964,218.00** | **613,192,841.22** |
| 210101 | Үндсэн цалин | 433,745,660.00 | 403,346,957.78 |
| 210102 | Нэмэгдэл | 137,322,583.00 | 165,025,596.44 |
| 210103 | Урамшуулал | 64,895,975.00 | 44,820,287.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **81,061,681.53** | **76,672,787.26** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 55,509,302.69 | 53,567,629.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,440,044.80 | 5,936,659.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,173,833.66 | 4,755,797.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,264,682.50 | 1,129,014.07 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,673,817.88 | 11,283,686.45 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **142,682,904.00** | **176,306,216.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,885,199.00 | 4,662,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 137,897,705.00 | 171,249,216.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,900,000.00 | 395,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,323,900.00** | **6,776,483.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 461,700.00 | 1,781,985.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,800,000.00 | 2,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 383,800.00 | 39,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 417,200.00 | 228,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,400.00 | 293,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 960,800.00 | 2,433,398.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **22,659,200.00** | **34,469,000.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 243,500.00 | 239,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,809,800.00 | 33,631,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 605,900.00 | 598,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,917,800.00** | **7,425,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 7,917,800.00 | 7,425,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **495,100.00** | **483,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 495,100.00 | 483,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,982,100.00** | **629,966.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,406,100.00 | 389,966.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,101,500.00** | **4,288,700.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 339,300.00 | 331,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,762,200.00 | 3,957,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **34,428,596.47** | **36,380,089.52** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг** | **2,573,100.47** | **19,405.52** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,573,100.47 | 19,405.52 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт** | **20,968,396.00** | **8,603,184.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,968,396.00 | 8,603,184.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **10,887,100.00** | **27,757,500.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 9,867,100.00 | 25,567,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1,020,000.00 | 2,190,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10,540,000.00** | **23,987,500.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,540,000.00** | **23,987,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,540,000.00** | **23,987,500.00** |
| **223** | **Бусад хөрөнгө** | **10,540,000.00** | **23,987,500.00** |
| 223004 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,540,000.00 | 23,987,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(10,540,000.00)** | **(23,987,500.00)** |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Э/З ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | - | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 942,515,200.00 | 908,957,703.53 | 995,218,500.00 | 966,596,010.48 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 942,515,200.00 | 908,957,703.53 | 995,218,500.00 | 966,596,010.48 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 929,729,100.00 | 898,070,603.53 | 967,461,000.00 | 938,838,510.48 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 635,984,300.00 | 635,964,218.00 | 613,197,700.00 | 613,192,841.22 |
| 210101 | Үндсэн цалин | 421,376,500.00 | 433,745,660.00 | 448,113,500.00 | 403,346,957.78 |
| 210102 | Нэмэгдэл | 165,301,500.00 | 137,322,583.00 | 130,586,300.00 | 165,025,596.44 |
| 210104 | Урамшуулал | 49,306,300.00 | 64,895,975.00 | 34,497,900.00 | 44,820,287.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 83,188,500.00 | 81,061,681.53 | 76,681,000.00 | 76,672,787.26 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 57,446,700.00 | 55,509,302.69 | 55,129,900.00 | 53,567,629.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,435,400.00 | 6,440,044.80 | 5,387,800.00 | 5,936,659.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,148,400.00 | 5,173,833.66 | 4,310,200.00 | 4,755,797.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,287,100.00 | 1,264,682.50 | 1,077,600.00 | 1,129,014.07 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,870,900.00 | 12,673,817.88 | 10,775,500.00 | 11,283,686.45 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 163,651,300.00 | 142,682,904.00 | 204,909,400.00 | 176,306,216.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,280,600.00 | 2,885,199.00 | 4,662,000.00 | 4,662,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 157,470,700.00 | 137,897,705.00 | 199,852,400.00 | 171,249,216.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,900,000.00 | 1,900,000.00 | 395,000.00 | 395,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,323,900.00 | 4,323,900.00 | 4,271,000.00 | 4,271,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 461,700.00 | 461,700.00 | 785,300.00 | 785,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,800,000.00 | 1,800,000.00 | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 383,800.00 | 383,800.00 | 39,500.00 | 39,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 417,200.00 | 417,200.00 | 407,000.00 | 407,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,400.00 | 300,400.00 | 293,100.00 | 293,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 960,800.00 | 960,800.00 | 946,100.00 | 946,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 31,159,300.00 | 22,659,200.00 | 34,469,000.00 | 34,469,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 243,600.00 | 243,500.00 | 239,100.00 | 239,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 30,309,800.00 | 21,809,800.00 | 33,631,400.00 | 33,631,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 605,900.00 | 605,900.00 | 598,500.00 | 598,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,843,100.00 | 7,800,000.00 | 30,425,000.00 | 30,425,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,843,100.00 | 7,800,000.00 | 30,425,000.00 | 30,425,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 495,100.00 | 495,100.00 | 483,000.00 | 483,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 495,100.00 | 495,100.00 | 483,000.00 | 483,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 982,100.00 | 982,100.00 | 636,200.00 | 629,966.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 406,100.00 | 406,100.00 | 396,200.00 | 389,966.00 |
| 210802 | Аудит зэрэглэл тогтоох | 576,000.00 | 576,000.00 | 240,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,101,500.00 | 2,101,500.00 | 2,388,700.00 | 2,388,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 339,300.00 | 339,300.00 | 331,100.00 | 331,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,762,200.00 | 1,762,200.00 | 2,057,600.00 | 2,057,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12,786,100.00 | 10,887,100.00 | 27,757,500.00 | 27,757,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,786,100.00 | 10,887,100.00 | 27,757,500.00 | 27,757,500.00 |
| **213205** | Төрөөс иргэдэд олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 11,766,100.00 | 9,867,100.00 | 25,567,500.00 | 25,567,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,020,000.00 | 1,020,000.00 | 2,190,000.00 | 2,190,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **942,515,200.00** | **908,957,703.53** | **995,218,500.00** | **975,218,600.00** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **771,020,800.00** | **758,474,799.53** | **759,884,100.00** | **759,884,200.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 771,020,800.00 | 758,474,799.53 | 759,884,100.00 | 759,884,200.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **171,494,400.00** | **150,482,904.00** | **235,334,400.00** | **215,334,400.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 171,494,400.00 | 150,482,904.00 | 235,334,400.00 | 215,334,400.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - | - | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 50 | 48 | 52 | 50 |
| 620001 | Удирдах ажилтан | 4 | 4 | 4 | 4 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 31 | 29 | 32 | 29 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 15 | 15 | 17 | 17 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1 | 1 | 1 | 1. |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 1 | 1 | 1 | 1 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 1 | 1 | 1 | 1 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | 50 | 48 | 52 | 48 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | | | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,392,983.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,392,983.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,492,983.00** |
| 2104 | Хангамж бараа материалын зардал | 3,492,983.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 996,685.00 |
| 210402 | Тээвэр шатахуун | 200,000.00 |
| 210404 | Ном | 809,000.00 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх | 1,487,298.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,900,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрийн дадлага | 1,900,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **5,392,983.00** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 5,392,983.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Ерөнхий Боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Чадварлаг аудит ХХК-ийн аудитор Б.Алтанцэцэг гүйцэтгэж, хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг,аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01-р сарын 16-ны өдрийн А/03 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Сурагчдыг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Зорилт-1 Төрийн албан хаагчийн болон багшийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

Зорилт-2 Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хяналттай зарцуулж, нийтэд ил тод мэдээлэхэд чиглэх

Зорилт-3 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

Зорилт -4 Багш сурагч хүүхэд нэг бүрийг төлөвшүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Есөнзүйл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2019 оны 01 сарын 21-ны өдрийн А/7 тоот тушаалаар баталж мөрдөж байна.

Сумын Ерөнхий Боловсролын Сургуулийн бүтцэд дотоод хяналтын орон тооны алба байхгүй. Сургуулийн захирлын 2019 оны 10 сарын 04-ны А/37 тоот тушаалаар Дотоод хяналтын нэгжийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллах журмыг мөн тушаалаар батлан хэрэгжүүлж ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Ерөнхий Боловсролын Сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 1223.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын хувьд тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 24.1 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 39.4 сая төгрөгөөр спортын заалыг засварласан. Сургуулийн хуучин байр 215.7 сая төгрөг, газар 4.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна. Бараа материалын хувьд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 995. 2 сая төгрөгийг улс,орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Санхүүжилт өмнөх оноос 5.8 хувиар өссөн байна. Энэ нь урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардал өссөнтэй холбоотой юм.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 966.6 сая төгрөгөөр санхүүжигдэн, 938.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага тайлант онд 5.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авч хангамжийн бараа материалын санхүүжилтэд 3.5 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 1.9 сая төгрөгийг авч зарцуулсан байна .

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайлант онд 6.0 сая төгрөгийн конторын тавилга хэрэгсэл худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүйгээс үүдэлтэй гарсан зөрчил юм. Мөн хөрөнгө зарцуулах шийдвэрүүдийн хувьд зэрэг дотоод хяналт нэр төдийн байдалтай холбоотой гарсан зөрчлүүд нь аудитын хувьд гол онцлох асуудал байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Шилэн дансанд Нийт 149 мэдээлэл оруулахаас 147 мэдээлэл оруулж 10 мэдээг хугацаа хоцроосон байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант хугацаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжид томоохон шинэчлэл өөрчлөлт гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн /*бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт* / нийцсэн/ байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3.0 сая төгрөгийн зөрчилд өгсөн албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Хөрөнгө зарцуулах тушаалуудын үндэслэл, тэдгээрийн хүчин төгөлдөр байдалд болон туслах аж ахуйн бүртгэлд анхаарах

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 6.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

**4.1 Залруулсан алдаа**

Байхгүй болно.

**4.2 Төлбөрийн акт**

Байхгүй болно.

**4.3 Албан шаардлага**

Хашхан ХХКомпаниас 2021 оны 12 сарын 13-ны өдөр 6.0 сая төгрөгөөр албан конторын тавилга худалдан авсан нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчсөн байна.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

1.1. <u>Илрүүлэлт:</u>

Шилэн дансанд Нийт 149 мэдээлэл оруулахаас 147 мэдээлэл оруулж 10 мэдээг хугацаа хоцроосон байна.

1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хуульд заасан хугацаанд мэдээллийг байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын | Нийт алдаа, зөрчлийн | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Залруулга | Төлбөрийн | Албан | Зөвлөмж |

| | нэр | | | | | акт | | шаардлага | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Есөнзүйл сумын ЕБСургууль | 1 | 6,0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 6,0 | 1 | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Б.АЛТАНЦЭЦЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР